

# “ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЦЭЦЭГЛЭЛ ХӨГЖИЛ: МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ҮҮРЭГ РОЛЬ”

Б.Лхагва

Стратегийн Судалгааны Хүрээлэн  
Зөвлөх судлаач, доктор (Ph.D)

## I. ЗХА-ийн бүс нутгийн өнөөгийн байдлын тухай товчхон

Энэ бүс нутаг бол дэлхийн энх тайван, хөгжил цэцэглэлийн тулгуур бүсийн нэг билээ. Дэлхийн хүн амын 1/4 энэ бүст амьдарч, дэлхийн GDP-гийн 25 хувь<sup>1</sup> энд үйлдвэрлэгдэж байна. Түүнчлэн EU болон NAFTA-гийн хамтаар дэлхийн худалдааны 3 том төвийг бүрдүүлж, дэлхийн ачаа тээврийн 30 хувь энд эргэлдэж байна. Нэгдсэн интеграци бүрдээгүй ч гэсэн КИЕР-ийн судалгааны дүнгээс үзэхэд ЗХА-ийн бүс нутаг дахь интеграцийн нийгэм соёлын хэмжүүрийн түвшин 3.67 байгаа нь EU (5.00), NAFTA(4.33)-д хараахан хүрэхгүй байгаа ч ASEAN(3.67) болон MERCORUS (3.67)-тай ижил, эдийн засгийн хамтын ажиллагаа нь Европын холбоо бүрэлдэх эхний шатанд явж байна.<sup>2</sup> Энэ бүхэн нь хөгжлийн асар их нөөц боломж юм.

Эдийн засаг, соёл, уламжлалт бус аюулгүй байдлын хүрээнд ийнхүү хамтын ажиллагаа тал бүрээр өргөжин хөгжиж, харилцан хамаарал нь гүнзгийрч байна. Харин харамсалтай нь улс төр, хамтын аюулгүй байдлын механизмын салбарт зөрчил, сөргөлдөөнт байдал хадгалагдаж, заримдаа бүр хурцдах хэмжээнд хүрч байна. Ийнхүү нэг талаар харилцан хамааралтай, нөгөө талаар зөрчил сөргөлдөөнтэй ийм нэг эерэг, сөрөг дүр төрх өнөөгийн ЗХА-ийн улс төрийн нөхцөл байдлыг тодорхойлж байна. Үүний улмаас тус бүс нутаг Европын Холбоо, АСЕАН шиг бүсийн цогц шинж чанараараа дэлхийн энх тайван, хөгжил цэцэглэлтэнд нэгдмэл хувь нэмрээ оруулж чадахгүй байна. Хүйтэн дайны үе дууссан ч тэр үеийн шарх сорви арилаагүй, улс төр, аюулгүй байдлын асуудлыг голдуу хоёр талын харилцааны түвшинд зохицуулах маягаар явж байна. Мөн Европын орнуудыг бодвол зөвхөн өөрийн улсын бүрэн эрхт байдлыг хэт дөвийлгөж ойлгох хандлага одоогийн шатанд давамгайлж байгаагаас шалтгаалж, олон талт хамтын ажиллагааны механизмаар дамжуулж аюулгүй байдлаа хангах сонирхол бага байгаагаас байдал ажиглагддаг.<sup>3</sup>

<sup>1</sup> 통일비전개발, 2011, 서울, pp.121

<sup>2</sup> 동북아지역통합내대한정치경제학적접근 [통합모델의모색과전략], 안형도, 박제훈, КИЕР대외경제정책연구원, 연구보고서 07-07, 2007, pp.75-76

<sup>3</sup> 동북아평화협력구상, 2014, 서울, pp.186-187

Үүнд бүсийн улс орнуудын өнгөрсөн зууны харилцаан дахь колончлолын бодлогын үр уршиг, түүний эсрэг чиглэсэн үндэсний үзлийн сэргэлт, болгоомжлол, үл итгэлцэл, өнөөгийн нийгмийн тогтолцоо, үзэл санаа, нийгмийн үнэт зүйлийн талаарх үнэлгээний ялгаатай байдал зэрэг олон талын хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Харин Азийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш олон талт хамтын ажиллагааны механизмаар дамжуулж тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахын давуу талыг эдгээр орнууд нэлээд бодитойгоор мэдэрч эхлэсэн. Ийм олон талт хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх бодит боломж чухам байгаа эсэх, байгаа бол ямар арга замаар бүрдүүлэх вэ зэрэг зарчмын асуудлуудад хандах хандлага, байр суурийн зөрөө, эргэлзээ гарах нь мэдээж боловч бүхэлд нь аваад үзэхэд ийм механизм хэрэгтэй гэсэн ойлголт, анхаарал, сонирхол нэг үеэ бодвол нэмэгдэж байгаа нь бодитой зүйл болоод байна. Эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагаа, энэ чиглэлд гарч буй санал санаачилгууд, хэрэгжүүлж буй олон талт томоохон төслүүд ч ийм чиглэлээр өрнөж байна. Бүсийн орнууд ч бас зүгээр гар хумхин суухгүй байна. Тухайлбал Ерөнхийлөгч Ро Дэ Ё 1988 онд “ЗХА-ийн энх тайвны Зөвлөл”, Ерөнхийлөгч Ким Ен Сам 1994 онд “ЗХА-ийн диалог”, Ерөнхийлөгч Ким Дэ Жүн 1998 онд “ЗХА-ийн аюулгүй байдлын олон талт диалог”, Ерөнхийлөгч Но Мү Хен 2004 онд “ЗХА-ийн энх тайван, хөгжил цэцэглэлийн эрин үе”, Японы Ерөнхий сайд Хатаяама 2009 онд “ЗХА-ийн интеграци” бүрдүүлэх тухай, түүнчлэн сүүлийн үед Ерөнхийлөгч Пак Гын Хэ 2013 онд “ЗХА-ийн энх тайван, хамтын ажиллагааны санаачилга”, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Улаанбаатарын яриа хэлэлцээ” хийх санал санаачилгууд дэвшүүлээд байгаа билээ. Мөн ARF, EAS –ын хажуугаар Хятад, БНСУ, Японы болон ОХУ, Монгол, БНХАУ-ын дээд хэмжээний гурвалсан уулзалтууд хийгдэж, зохих үр дүнгээ өгч байна.

## **II. Тулгарч буй сорилтууд**

ЗХА-д аюулгүй байдлын хамтын ажиллагааны олон талт механизм бүрдүүлэхэд дараах үндсэн 3 гол хүчин зүйл саад тотгор учруулж байна. Үүнд:

### **1. Бүс нутагт хамаарах их гүрнүүдийн стратегийн зөрчил**

ЗХА-ийн бүсийн энхийн дэг журамд нэг хэсэгтээ АНУ, БНХАУ хоёр гол үүрэг гүйцэтгэх нь тодорхой байна. Энэ нь одоогоор АНУ-ын “Pivot to Asia”, “Rebalancing” стратегиар, Хятадын “New model of major country relationship” бодлогоор илэрч байна. Энэ байдал нь АНУ, Хятад хоёрыг хамтран ажиллангаа өрсөлдөхөөс өөр аргагүй байдалд хүргэж байна. Мөн тодорхой зарим асуудлаар

харилцан ойлголцолд хүрэх эрмэлзэл хэн хэнд нь байгаа хэдий ч итгэлцлийн түвшин доогуур байна. Түүнчлэн үзэл санаа, үнэт зүйлд хандах нийгмийн сэтгэлгээ, улс төрийн тогтолцоо, үл итгэлцэл зэрэг нь олон улсын дэг журам тогтоох чиглэлд хойшид нэмэлт шинэ зөрчил үүсгэхийг үгүйсгэх аргагүй юм.

ОХУ нь өрнөд рүү чиглэсэн уламжлалт бодлогоо хадгалангаа Ази, Номхон Далайн бүс нутагт өөрийн гэсэн орон зайтай болохыг эрмэлзэж байна. Гэхдээ тус улс АНУ, Хятад шиг улс төр, аюулгүй байдал гэхээс илүүтэй ЗХА, Алс Дорнодын бүс нутагт эдийн засгийн олон талт хамтын ажиллагаанд илүү анхаарсан прагматик бодлого барьж байна. Үнэндээ Курилын арлуудын асуудлаас өөрөөр ОХУ-ын эрх ашгийг хөндөх, Оросын аюулгүй байдалд шууд хохирол учруулах тийм асуудал одоогоор энэ бүс нутагт бага байх шиг байна.

## **2. ЗХА-ийн бүс нутгийн орнуудын хоорондын зөрчил**

Сүүлийн жилүүдэд нэлээд асуудал болж, заримдаа ноцтой сөргөлдөөнд хүрч болзошгүйгээр хурцдаж буй бүс нутгийн газар нутгийн болон өнгөрсөн түүхийн холбоотой маргаан зэрэг зөрчлүүд үүнд хамрагдаж байна. 1980-аад оноос Азийн зарим оронд газар авч эхлээд байгаа үндэсний үзлийн сэргэлт, байгалийн баялагийн төлөөх өрсөлдөөн нь өнгөрсөн үеийн колончлолын бодлого, түүхийн шарх сорвийг сэдрээх үндсэн шалтгаан болж байна. Энэ зөрчил, маргаан нэг хэсэгтээ үргэлжлэх төлөвтэй.

## **3. Солонгосын Хойгийн тогтворгүй байдал, Умард Солонгосын цөмийн зэвсгийн асуудал**

Энэ асуудлыг Та бүхэн биднээс илүү сайн мэдэх учраас товчхон хэдэн санаа хэлье гэж бодож байна.

Солонгосын Хойгийн тогтвортой байдал нь ЗХА-ийн бүс нутгийг энх тайван, цэцэглэл хөгжлийн хамтын талбар болгоход чухал ач холбогдолтой билээ. Үүний тулд юуны өмнө тус Хойгийг цөмийн хөтөлбөрөөс ангид байлгах асуудал дээр олон орон санал нэгдэж байна. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай түгээмэл эрх ашиг, түүний дотор манай бүс нутгийн хэмжээний хөгжлийн нийтлэг эрх ашиг үүнийг шаардаж байна. Гэтэл Умард Солонгосын эрх баригчид үүний эсрэг алхам хийж, байдлыг тогтворгүйжүүлж буйн улмаас Солонгосын Хойг манай бүс нутаг дахь хүйтэн дайны үеийн цорын ганц түгшүүртэй голомт болон үлдээд байна.

Одоогоор Умард Солонгосын эрх баригчид асуудлыг нааштайгаар шийдвэрлэх төлөв харагдахгүй байна. Яриа хэлэлцээ зогсонги байдалд ороод багагүй хугацаа өнгөрлөө. Урьд өмнөх хоригууд ч төдийлөн үр дүнгээ өгсөнгүй.

Харин энэ удаагийн хоригт БНХАУ, ОХУ харьцангуй тууштай байр суурьтай байгаагаас гадна Европын Холбоогоор зогсохгүй Уганда, Ангола, Мозамбик зэрэг Умард Солонгосын Африк дахь түншүүд болон уламжлалт харилцаатай явж ирсэн хуучин социалист зарим орон анхаарлаа хандуулж, Пхеньянтай харилцах харилцаа нь зарим талаар хумигдаж буйг сүүлийн үеийн үйл явдлууд харуулж байна. Мөн Умард Солонгосын цөмийн хөтөлбөрт шүүмжлэлтэй хандаж байгаа нь ойрмогхон Монголд зохинон байгуулагдсан ASEM, Лаост хуралдсан ARF-ын чуулганы албан ёсны баримт бичгүүдээс ажиглагдав.

Умард Солонгосын эрх баригчдын өнөөгийн хамгийн тулгамдсан зорилт нь тэдний үзэж байгаагаар систем, засаглалаа хадгалж авч үлдэх явдал аж. Чингэхдээ цөмийн хөтөлбөр, эдийн засаг хоёрт гол найдлага тавьж байна. Цөмийн хөтөлбөрийн улмаас гадаад ертөнцөөс тусгаарлагдаад байна. Дотоод улс төрийн байдал эдийн засгаас шалтгаална. Тийм ч тогтвортой биш байгаа бололтой. Энэ оны эхний хагаст 800 гаруй хүн Өмнөд тал руугаа зугтан орж, өнгөрсөн оны мөн үеэс өссөн нь тогтворгүй байгаагийн шинж тэмдэг болов уу. Энэ удаагийн хориг арга хэмжээ Пхеньянд ямаршуу нөлөө үзүүлэхийг харзлах хэрэгтэй боловч ер нь хориг үргэлжилсэн ч, эс үргэлжилсэн ч, цөмийн зэвсгээр хөөцөлдсөн ч, эс хөөцөлдсөн ч эцсийн дүндээ гаднын дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагаагүйгээр эдийн засгийн салбарт тавьж буй зорилтоо бие дааж шийдвэрлэхэд нь хязгаар бий. Дэмжлэг туслалцаа авч, хамтын ажиллагаанд оролцохын тулд хэрвээ дотоодод нь нийгмийн гэнэтийн өөрчлөлт гардаггүй л юм бол тэд хүссэн ч хүсээгүй ч хэлэлцээний ширээнд эргээд суухаас өөр арга байхгүй. Одоохондоо АНУ, БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг хүлээж байгаа байх.

Харин бид бүс нутгийн хамтын ажиллагаанд Умард солонгосыг ямар арга замаар татан оруулах боломж байгааг сайтар судлаж бэлтгэх ёстой. Мөн ийм хамтын ажиллагаанд оролцох замаар бүс нутгийн тогтвортой байдлыг хангах нь тэдний өөрсдийнх нь хүсээд байгаа тэрхүү систем, дэглэмийн оршин тогтнох үйл явцад эерэг нөлөө үзүүлнэ гэдгийг бас ойлгуулах нь бидний хийх ажлын нэг чиглэл байх ёстой болов уу.

Зургаан талт хэлэлцээнээс гадна Солонгосын хоёр талын яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа сэргэх нь тодорхой. Мэдээж Солонгосын хоёр тал гол субъект мөн хэдий ч Солонгосын асуудлыг зөвхөн энэ хоёр талын хүрээгээр хязгаарлахгүй ЗХА-ийн энхийн дэг журмын өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй болов уу гэж бодогдож байна. Үүний тулд Солонгосын хоёр талын хажуугаар бүс нутгийн орнуудын зүгээс Умард Солонгостой харилцах асуудлыг уялдуулан зохицуулах шаардлага гарах байх. Өөрөөр хэлбэл, Пхеньяныг Солонгосын хоёр талын харилцааны хүрээнд ч, бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд ч татан

оролцуулах арга замыг давхар эрэлхийлэх хэрэг гарна. Ийм арга замын нэг нь Солонгосын хоёр тал энх тайвнаар зэрэгцэн оршиж, хамтарч ажиллаж болохуйц тийм эвлэрэл, хамтын ажиллагааны таатай орчин нохцөлийг бүрдүүлэх явдал байж болох юм. Энэ нь өргөн утгаараа Солонгосын Хойгт энхийн дэг журам тогтоох хүчин зүйлсийн нэг болж өгч ч магадгүй. Багагүй зөрчил, сөргөлдөөн хуримтлагдсан Европт аюулгүй байдлын олон талт механизм бүрдүүлэхэд хүргэсэн хүчин зүйлүүдийн нэг бол амжилттай өрнүүлж чадсан энх тайвнаар зэрэгцэн орших стратеги байсан туршлага бий.

Энх тайвнаар зэрэгцэн орших таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд Умард Солонгос өөрийнхөө аюулгүй байдалд олон улсын баталгаа шаардана. Энэ баталгааны хүрээнд эхлээд Энхийн хэлэлцээр байгуулж, АНУ-тай төрийн харилцаа тогтоох болзол тавигдана. Харин хоёр талын байр суурь зөрөөтэй өнөөгийн нөхцөлд Солонгосын Хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох, Энхийн хэлэлцээр байгуулах асуудлыг зэрэгцүүлэн урагшлуулах БНХАУ-ын саналыг харгалзаж үзэх хувилбар яригдаж магадгүй. Үүнээс гадна Солонгосын Хойгт энхийн дэг журам тогтоохтой холбогдуулан Үндэсний нэгдлийн Хүрээлэнгийн захирал асан доктор Квак Тэ Хваны дэвшүүлсэн санал, зөвлөмжийг ч бас анхаарууштай.<sup>4</sup>

Ер нь Солонгосын Хойгт тайван тогтвортой байдал тогтоох 3 үндсэн арга зам харагдаж байна.

**Нэгт:** Умард Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд хоёр тал өөр өөрсдийн системээ нэг хэсэгтээ хадгалан, аюулгүй байдлаа хангаж, энх тайвнаар зэрэгцэн оршин орших,

**Хоёрт:** Умард Солонгос нээлттэй нийгэмд шилжих, аль эсвэл дотоодод нь гэнэтийн өөрчлөлт гарч систем нь задран нурах,

**Гуравт:** Яваандаа энх тайван замаар нэгдэж нийлэх эдгээр болно. Эхнийх нь цөмийн асуудалтай тулгарч буй. Хоёр дахь чиглэлд хязгаарагдмал ч гэсэн үйлчилгээ, арилжааны салбарыг голлон зах зээлийн элементүүд үүсч нэлээд тэлж байгаа; түүнийг дагалдан мөнгөний үнэр авсан нийгмийн шинэ давхарга үүсч байгаа; иргэд хоорондын харилцаа холбооны цоо шинэ сүлжээ үүссэн; гадны мэдээлэл, нөлөөлөл нэвтрэх хүрээлэл дунд оршиж байгаа; хээл хахуул газар авч байгаа; Умард Солонгосоос дайжин зугтан гарч буй олон мянган хүний урсгал элитийнх нь хүрээг хамарч эхэлж буй зэрэг урьд өмнө нь байгаагүй, төв Засгийн газрын хяналтаас бүрэн болон бүрэн бус хамааралтай шинэ өөрчлөлтүүд гарч буй нь анхаарал татаж байна. Гэхдээ бүхэлдээ нээлттэй нийгэмд шилжинэ гэж найдах нь хэтэрхий эртэдсэн хэрэг болно. Нийгэм дотроосоо задрах магадлал одоогоор бага байх шиг байна. Задарлаа ч тэр нь

<sup>4</sup> Thkwak38@hotmail.com, 한반도평화구축을위한새로운대안모색해야, 2016.02.10

эрсдэл ихтэй. Харин хамгийн найдвартай хувилбар нь гурав дахь арга зам юм. Гэвч Умард Солонгос хоёр талын харилцааг сайжруулахаас болгоомжилж, үндэсний нэгдлийн асуудалд хориглолт, хамгаалалтын байр сууринаас хандаж байна. Тэдний үзэж буйгаар ер нь гадаад орчин нөхцөл бүхэлдээ таагүй байгаа бололтой.

Нөхцөл байдал ямараар ч өөрчлөгдлөө гэсэн үндэсний хуваагдмал байдлаа гэтлэн давах туйлын зорилтоосоо Солонгос татгалзахгүй болов уу. Олон эрх ашиг сүлжилдсэн ээдрээ түвэгтэй энэ зорилтыг хэрэгжүүлэх нь зөвхөн Солонгосын асуудал биш болоод байна. Бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны тусын тулд энэ асуудалд юуны өмнө бүс нутгийн орнуудын ойлголт, хамтын ажиллагаа чухал.

Монгол улс бол Солонгосын Хойгийг нэгдээсэй гэж чин сэтгэлээсээ хүсдэг орнуудын нэг. Тэгэх учир шалтгаан ч бий. Монголчууд бид Солонгосыг Өмнөд, Умард гэж хувааж харахаасаа илүүтэй угаасаа нэгдмэл нэг үндэстэн гэж ханддаг. Сэтгэхүйн энэ өвөрмөц онцлогоороо бусад улс, зндэстнээс ялгаатай байж магадгүй. Монгол улсын Засгийн газар Солонгосын энх тайван нэгдлийг тууштай дэмжиж ирсэн. Манай судалгааны байгууллагууд, судлаач, шинжээчид, олон нийтийн байгууллагууд ч мөн ийм байр суурьтай байдаг. Үүний нэг тодорхой илрэл нь Солонгосын Нэгдлийг Дэмжих Монголын Форум (Mongolian Forum for Korean Unification) 2015 онд байгуулагдаж, Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат уг байгууллагыг толгойлон ажиллаж байгаа явдал юм. Бидний цаашдын зорилт энэ үйл ажиллагааг ЗХА, Төв Азийн хүрээнд бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэх явдал юм.

### **III. ЗХА-ийн олон талт хамтын ажиллагааны механизм бүрдүүлэхэд Монгол улс, БНСУ-ын хамтарч гүйцэтгэх үүрэг, роль**

Энэ чиглэлд манай хоёр улс хамтарч ажиллах 2 төрлийн боломж харагдаж байна. Нэг дэх нь цөмийн зэвсэггүй бүсийн төлөөх хамтын ажиллагаа, Хоёр дахь нь Улаанбаатарын яриа хэлэлцээ, ЗХА-д энх тайван, хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай санаачилгыг уялдуулан хамтран ажиллах явдал болно.

Нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид бүс болгох нь Монгол улсын аюулгүй байдлын бодлогын үндсэн чиг шугам мөн. Энэ зорилт Монгол улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан. Манай улс энэ чиг шугамаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1992 оны индэр дээрээс албан ёсоор тунхагласан бөгөөд НҮБ 1998 онд түүнийг дэмжсэн тогтоол баталсан. Р5 2000 онд Аюулгүйн Зөвлөлийн албан ёсны баримт бичиг болгон тараасан. Монгол улсын энэ зорилт бол зөвхөн өөрийн улсын аюулгүй байдлын

асуудлаар хязгаарлагдах төдий асуудал биш бөгөөд бүс нутагт бат бэх энх тайван тогтоохын төлөө давхар хийсэн алхам юм.

Монгол улс дипломат харилцаатай 170 гаруй улсын дотроос аравтай нь түншлэлийн гэрээтэй бөгөөд тэдгээрийн дөрөв нь ЗХА-ийн орнууд. Түүнчлэн манай улс бүс нутгийнхаа орнуудтай газар нутаг, түүхийн маргаангүй, бүгдтэй нь жигд харилцаатай, аль нэг их гүрэнтэй цэргийн холбоотны харилцаа тогтоогоогүй, харьцангуй төвийг сахисан байр суурьтай байгаа. Монголын хувьд Солонгосын Хойгт нөлөөгөө бэхжүүлэх стратегийн ямар нэгэн эрх ашиг байхгүй. Байх ёстой гэвэл тэр нь бүсийн энх тайван, хамтын цэцэглэл хөгжлийн эрх ашиг байж таарна.

Монгол улс 6 талт хэлэлцээнд оролцогч биш боловч АНУ-Умард Солонгос, Япон-Умард Солонгосын уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулж ирсэн нь бүс нутгийн энхийн зорилгын үүднээс авсан арга хэмжээ юм.

Эцэст нь “Улаанбаатарын яриа хэлэлцээ”, “Зүүн Хойд Азийн энх тайван хамтын ажиллагааны санаачилга” гэсэн хоёр улсын саналыг хооронд нь уялдуулж урагшлуулах талаар хамтарч ажиллах ямар боломж байж болох вэ гэдэг талаар хувийн хэдэн санаа хэлье.

Юуны өмнө энэ хоёр саналаас зорилго, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга замтай нь холбогдсон хэд хэдэн ижил төстэй зүйлүүдийг олж харж болох байна. Үүнд:

- Бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх гэсэн гол зорилт агуулж, тэр чиглэлд холбогдох орнуудын анхаарлыг хандуулсан байна.
- Асуудлыг шийдэхдээ хүч түрэх [Hard Power] аргаар биш зөөлөн хүчний бодлогоор [Soft Power] зохицуулахыг үндсэн зарчмаа болгож, тэгэхдээ уламжлалт бус аюулгүй байдлын нийтээр хүлээн зөвшөөрөх, тулгамдсан, түгээмэл энгийн асуудлуудыг эхэлж авч хэлэлцэж шийдвэрлэх замаар урагш ахих гэсэн арга замыг сонгосон байна.
- Өөр нэг маш чухал асуудал тусгагдсан нь ЗХА-ийн бүс нутагт ихээхэн доогуур түвшинд яваа илтгэлцлийг бэхжүүлэхийг зорьсон явдал юм. Шийдвэрлэж болох асуудлуудаасаа барьж авч шийдвэрлэх замаар итгэлцлийг алхам алхмаар бэхжүүлэнгээ, тодорхой хэмжээний итгэлцэл бүрдсэний үндсэн дээр зөрчил, сөргөлдөөний үндсэн саад бэрхшээлийг багасган арилгах чиглэл өөд аажмаар ахих санаа дэвшүүлсэн байна. Энэ нь уламжлалт бус аюулгүй байдлын чиглэлд нэлээн сайн хамтарч ажилласны үндсэн дээр уламжлалт аюулгүй байдлын чиглэл рүү шилжье гэсэн хэрэг гэж ойлгогдож байна.

- Аюулгүй байдлыг хангахад бүс нутгаа цөмийн зэвсгээс ангид байлгах зорилт дэвшүүлж байгаагаараа ижилхэн байр суурьтай байна.
- Нөхцөл бүрдсэний дараа дээд хэмжээний уулзалт хийж, үр дүнгээ баталгаажуулан зорилтоо тодорхойлох маягаар бүтэц, зохион байгуулалтын механизм руу орохоор төлөвлөсөн байна.
- Зөвхөн өөрийн бүс нутгаар хайрцаглагдахгүйгээр Зүүн Азийн болон сонирхогч талуудад нээлттэй байгаагаараа ижил төстэй байна.
- Түүнчлэн манай хоёр улс хоёулаа Европын Аюулгүй Байдлын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд.

Бид энэ мэт нэг зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ижил төстэй талууддаа түшиглэн уг хоёр саналыг хооронд нь уялдуулж урагшлуулах талаар хамтарч ажиллах шаардлагатай байна.